



АВЛИГАТАЙ  
ТЭМЦЭХ ГАЗАР

*Шударга ёс, хөгжил дэвшилд*

**МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ  
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ  
ТОЙМ ТАНИЛЦУУЛГА**



(2019.05.02-2020.05.02)

## ГАРЧИГ

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ .....	4
АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ.....	6
ХЭРЭГ ИЛРҮҮЛЭХ, МӨРДӨН ШАЛГАХ АЖЛЫН ҮР ДҮН, ШИНЭЧЛЭЛ.....	9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМЖУУЛАЛТ .....	11
АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙН СУДАЛГАА, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ.....	15
АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ .....	17
ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМ, ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД АВЛИГЫН ЭРСДЭЛ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ.....	19
ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАХ АЖЛЫН ШИНЭЧЛЭЛ .....	20
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО .....	28
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА .....	40

## МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ТОЙМ ТАНИЛЦУУЛГА

(2019.05.02-2020.05.02)

*Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын цйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн өргөн оролцоотойгоор улсын хэмжээнд зохион байгуулав.*

*Авлигатай тэмцэх бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээг тоймлон танилцуулж байна.*



## БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ



### **Авлигатай тэмцэх газрын даргаар З.Дашдаваа, дэд даргаар Ж.Батсайхан нарыг томиллоо**

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтыг үндэслэн Зандраагийн Дашдавааг Авлигатай тэмцэх газрын даргаар, Жанжаагийн Батсайханыг Авлигатай тэмцэх газрын дэд даргаар томиллоо.

### **Бүтэц, орон тоог шинэчлэн тогтоов**

Монгол Улсын Их Хурлын хаврын чуулганы 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар “Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлснээр уг төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 69.6 хувь нь дэмжиж баталгаажуулав.




### **АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа:**

*Авлигын эсрэг даян дэлхийн хөдөлгөөн болох “Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагаас Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын ажилтан, албан хаагчдын ачаалал хэт их байгаагаас үр дүн муутай байдаг талаар дүгнэлт гарсан. Иймд урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хяналт шалгалт, хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгах чиг үүргийг хэрэгжүүлдэг албан хаагч, ажилтнуудынхаа ачааллыг зохистой түвшинд хүргэх шаардлага бий.*

## АТГ-ын стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхлэв

Авлигатай тэмцэх газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн тушаалаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилттой уялдуулан “Авлигатай тэмцэх газрын стратеги төлөвлөгөө (2020-2023)”-г баталлаа.

АТГ-ын стратегийн зорилгууд нь өөр хоорондоо нягт уялдаатай хэрэгжинэ.



**Алсын хараа:**  
Шударга ёсны төлөө иргэдийн итгэл хүлээсэн байгууллага байна.

**Бидний уриа:**  
Шударга ёс,  
хөгжил дэвшилд

**Эрхэм зорилго:**  
Авлигатай тэмцэж,  
шударга ёсыг  
тогтоон хөгжил  
дэвшилд хүргэнэ.

## АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ

### Улсын Их Хурлын гишүүд ёс зүйн манлайлал үзүүлж ажиллах ёстой

Авлигатай тэмцэх газраас Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгох тухай хэд хэдэн санал хүргүүлсний дотор “Улсын Их Хурлын гишүүдийн ёс суртахуун, шударга, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх” санал байв.

Ард түмний элч болсон Улсын Их Хурлын гишүүдийн холбогдсон хэрэг, зөрчил сүүлийн жилүүдэд цөөнгүй гарч байгаа нь

төрийн албаны нэр хүнд, дархлаанд сөргөөр нөлөөлж байна. Улсын Их Хурлын гишүүний үг, үйлдэл, үйл ажиллагаа бүр нь нийт ард түмний байнгын хараа хяналтад байж, шударга ёс, хууль ёс бодитоор хэрэгжиж байгаа эсэхийн баталгаа, шалгуур болдог тул энэхүү үүрэг хариуцлага, манлайллыг Улсын Их Хурлын гишүүн нь тангараг өргөсөн эхний өдрөөсөө ухамсарлан мэдэрч байвал зохилтой.

Улсын Их Хурлын гишүүний тангаргийн үгийг “Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрийн хуулийг дээдлэн сахиж, **авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж**, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ” гэж өөрчлөх

Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөх дэгд “Сонгуулийн ерөнхий хорооны дарга илтгэл тавьсны дараа гишүүн нэг бүр насны эрэмбээр, Монгол Улсын Үндсэн хууль дээр гараа тавьж, тангаргийн үгийг цээжээр уншиж тангараг өргөнө” гэж өөрчлөх.



### **УИХ-ын дарга Г.Занданшатар:**

Авлигатай тэмцэх газраас УИХ-ын гишүүдийн тангарагийн үг болон тангараг өргөх дэгт зарим өөрчлөлт оруулахаар саналаа ирүүлсэн. Үүнийг УИХ-ын чуулганы дэгийн тухай хуульд болон УИХ-ын тухай хуульд оруулахаар төлөвлөж байна. АТГ нь шинэлэг хандлага, олон улсын туршлага, цахим засаглал, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр олон ажил хийхээр төлөвлөн УИХ-д багц саналуудаа ирүүлсэн. УИХ-ын гишүүдийн ёс суртахуун, шударга, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг гол зорилго. Төрийн түшээд, УИХ-ын гишүүд маань шударга ёс, сахилга хариуцлага дээрээсээ ингээд үлгэрлээд эхэлбэл доор шударга ёс тогтоно.



### **АТГ-ын дарга, тэргүүн комиссар**

#### **З.Дашдаваа:**

УИХ-ын гишүүн “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж...” гэж ард түмний өмнө тангараг өргөснөөр ард түмний төлөөлөл гэдгээ ухамсарлах болно. Энэ нь УИХ-ын гишүүнийг гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэг хэлбэр юм.

### **Мэдээлэгч (шүгэл үлээгчийг) хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлаар зөвлөмж гаргав**

Монгол Улсад нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс зүй бус үйлдэл, хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл өгч буй “шүгэл үлээгч”-ийг болзошгүй эрсдэлээс хамгаалах болон урамшуулах, холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор “Мэдээлэгчийг хамгаалах бодлого, арга зам” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн төслийг боловсруулах төслийн үр нөлөөний үнэлгээ, судалгааны ажлыг гүйцэтгүүлэх, хууль санаачлагчид уламжлах зэрэг асуудлаар зөвлөмж гаргав.

### **“Шүгэл үлээгч”-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-ын даргад хүргүүлэв**

Улсын Их Хурлын даргын өгсөн чиглэлийн дагуу Авлигатай тэмцэх газраас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл,

## Шударга ёс, хөгжил дэвшилд

дагалдан гарах дараах хуулийн төслийг боловсруулж УИХ-ын даргад хүргүүлээ.



Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай



Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай



Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай



Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг болно.

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч (илчлэгч)-ийг дэмжих чиглэлээр Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлж, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээн иргэний эр зориг гарган хариуцлага үүрч, эрх мэдэлтэн, албан тушаалтан, төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарч буй зүй бус үйлдэлд нийгмийн анхаарлыг чиглүүлэн, шударга ёсыг тогтоохын төлөө нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүр тавьж байгаа шүгэл үлээгч (илчлэгч)-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх үндэслэл, журмыг тогтоов.

## Авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэв

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслийг хууль санаачлагчдад уламжлаад байна.

Авлигатай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр:

- ▶ Авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлдэггүй байх
- ▶ Олон нийтийн зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтыг ил тод болгох,
- ▶ Улс төрийн намын санхүүжилтийн механизмыг ил тод, хариуцлагатай болгох
- ▶ Шүүгчийн сонгон шалгаруулалтыг ил тод болгох
- ▶ Авлигын гэмт хэргийн дагнасан шүүх байгуулах зэрэг асуудлаар санал боловсруулж Улсын Их Хуралд хүргүүлэв.



## ХЭРЭГ ИЛРҮҮЛЭХ, МӨРДӨН ШАЛГАХ АЖЛЫН ҮР ДҮН, ШИНЭЧЛЭЛ

### Хугацаа сунган шалгагдаж байгаа 37 хэргийг шийдвэрлэв

2019 оны 05 дугаар сарын байдлаар тус газарт шалгагдаж байсан **425** хэргээс олон нийтийн анхаарал татсан, ээдрээ төвөгтэй, ажиллагаа ихтэй, удаан хугацаагаар шалгагдаж буй **54** эрүүгийн хэрэг байснаас **37** хэргийг хуульд заасны дагуу шийдвэрлэж, үлдэгдэл **17** хэргийг энэ оны эхний хагаст багтаан шийдвэрлэхээр ажиллаж байна.

Эдгээрт Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Төв банкны Ерөнхийлөгч, нийслэлийн Засаг дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга зэрэг улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн холбогдсон хэргүүд хамаарч байна.

**2** жилээс дээш хугацаагаар  
шалгагдаж байсан

Улс төрд нөлөө бүхий **30**  
этгээдэд холбогдох

**54** ЭРҮҮГИЙН ХЭРГЭЭС


**37** эрүүгийн хэргийг  
(68.5%)

**ШИЙДВЭРЛЭВ**


## Мөрдөн байцаалтын шатан дахь хохирол нөхөн төлүүлэлт **49** дахин өсөв

2020 оны эхний дөрвөн сарын байдлаар **806** хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ. Эдгээр гэмт хэргийн улмаас **11.8** их наяд төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад **9.7 их наяд** төгрөгийн хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан, **18.3 тэрбум** төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн дүн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **49** дахин өссөн байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, битүүмжилсэн хөрөнгө, (тэрбум төг)



Битүүмжилсэн хөрөнгө **75** дахин, хохирол нөхөн төлүүлэлт **49** дахин өсөв



2019 оны эхний 6 сард

2020 оны эхний 5 сард

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМЖУУЛАЛТ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн цахим мэдээллийн нэгдсэн сантай болов.



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр нь “Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх” зорилгыг хангахаар 11 зорилтыг дэвшүүлж, 83 үйл ажиллагааг 2016-2023 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн цахим сантай болсноор хэрэгжилтийн тайлан, мэдээг цахимаар авч, хяналт шинжилгээ, үнэлгээ, баяжилт хийх боломж бүрдлээ.

### Сургалтын бүртгэлийн нэгдсэн системийг нэвтрүүлээ

Бүртгэлийн цахим систем нэвтэрснээр цаас, цаг үрсэн гар ажиллагааг халж, төрийн байгууллагууд сургалтад хамруулах албан тушаалтны захиалгыг онлайнар өгөх, сургалт зохион байгуулж байгаа өдөр, цаг хугацааны мэдээллийг авах, сургалтад хамрагдсан ажилтныхаа ирцийн байдалд хяналт тавих, дүн шинжилгээ хийх боломжтой болов.



### Төрийн таван байгууллагын цахим мэдээллийг хайлтын нэг системд орууллаа

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нээлттэй өгөгдлийг ашиглан олон нийтийн зүгээс хяналт тавих, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор “Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв”, “Нээлттэй нийгэм форум” ТББ-уудтай хамтран нээлттэй өгөгдлийн сан [www.opendatalab.mn](http://www.opendatalab.mn) цахим хайлтын системийг хөгжүүлэв. Энэхүү хайлтын системд хөрөнгө, орлогын мэдүүлэг, худалдан авах ажиллагаа, улсын бүртгэл, уул уурхайн лиценз, сонгууль гэсэн категори бүхий:



**197085** байгууллага



**489494** хувь хүн



**17026** тендер



**73189** албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг




**3356** уул уурхайн лиценз, зөвшөөрөл



**16** визуал дата, бүх сонгуулийн мэдээллийг багтаасан.

### Сахилгын шийтгэл хүлээсэн этгээдийг нийтэд мэдээлж байна




Авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийг зөрчсөний улмаас сахилгын шийтгэл хүлээсэн нийтийн албан тушаалтан энэ тухайгаа өөрийн зардлаар нийтэд мэдээлэх зохицуулалтыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд тусгасан.

“Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын 4.2-т зааснаар сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийн нэгдсэн сан үүсгэж [www.iaac.mn](http://www.iaac.mn) цахим хуудсаар олон нийтэд мэдээлж байна.

## Цаасан бус цахим хяналт

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшиж байгаа иргэдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цаасаар хүлээн авах ажиллагаанаас татгалзаж, цахимаар бүртгэх шинэчлэлийг өргөжүүлж нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн **3008** этгээдийн ХАСУМ-ийг цахимаар хүлээн авч, хариуг хүргүүлсэн байна.



Төрийн албыг мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх зорилтын хүрээнд болон Авлигатай тэмцэх үндэсний

хөтөлбөрийн 4.1.1-д заасан "Шударга хариуцлагатай ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх" үйл ажиллагааны хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл олгосон нийт **16500** гаруй төрийн захиргааны албан хаагчийн "Албан тушаалын тодорхойлолт"-ыг гаргуулан авч, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд нь тухайн ажлын байранд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

## Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг анх удаа зарлана

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг цахимаар бүртгэх, хүлээн авах, цахим мэдээллийн сүлжээнд нээлттэй байршуулахаар сонгуулийн хуульд орсон өөрчлөлтийн дагуу холбогдох зохион байгуулалтын ажлыг цахим шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэж байна.

[www.meduuleg.iaac.mn](http://www.meduuleg.iaac.mn) цахим системд зарим техникийн өргөтгөл, шинэчлэлтийг хийж, хуульд зааснаар УИХ-д нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг анх удаа иргэд, олон нийтэд нээлттэй танилцуулахаар ажиллаж байна.

## ➤ Шударга ёс, хөгжил дэвшилд

Сонгуулийн ерөнхий хороотой хамтран 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвшигч нарт зориулсан гарын авлага, зөвлөмжийг боловсруулж нам эвсэл, бие даагч нарыг мэдээлэл арга зүйгээр ханган ажиллаж байна.



### Өргөдөл, гомдол хүлээж авах, албан бичиг хөтлөлтийн програм шинэчлэгдэв

Үндэсний статистикийн хорооны 2019 оны А/189 дүгээр тушаалаар баталсан зөвшөөрлийг үндэслэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 30, захиргааны 6 маягт, гэмт хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн мэдээ, тоо бүртгэлийн журмыг баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өргөдөл, гомдол, бичиг хэрэг, гэмт хэргийн мэдээллийн шинэчлэгдсэн програмыг ажиллагаанд оруулсан.

Энэхүү тушаал батлагдсанаар Авлигатай тэмцэх газар 2020 оноос өргөдөл, гомдол, гэмт хэргийн улсын хэмжээний статистикийг албан ёсоор бүрдүүлэх боломж бүрдлээ.

### ХАСХОМ-ийн програмын шинэчлэлт

Нийтийн албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын ажлыг явуулахдаа мэдүүлэг гаргагчийн сүүлийн таван жилийн мэдүүлгийн харьцуулалтыг компьютерт нэг бүрчлэн шивж оруулдаг байсныг өөрчилж програмын шинэчлэлтийн ажлыг хийж байна.

Ингэснээр хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах ажлын үр дүнг дээшлүүлж, цаг хугацаа хэмнэж байна.

№	Нэр	Төлөв	Тайлбар
1	...	...	...
2	...	...	...
3	...	...	...
4	...	...	...
5	...	...	...
6	...	...	...
7	...	...	...
8	...	...	...
9	...	...	...
10	...	...	...

## АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙН СУДАЛГАА, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

### **110** тусгай дугаарын утсыг ажиллуулж эхэллээ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт “авлигын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах үйл ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах, гомдол, мэдээлэл утсаар өгөх боломжийг бүрдүүлэх” зорилт тусгагдсан билээ.


Авлигатай тэмцэх газар нь гомдол, мэдээлэл хүлээн авах зорилгоор 2007 оноос 1969, 2014 оноос 1800-1969 дугаарын утсыг ажиллуулж байсан бөгөөд тус газар нь 2019 оны эхний 9 сарын байдлаар нийт 1416 гомдол, мэдээлэл хүлээн авсны 192 буюу 13 хувийг утсаар ирүүлсэн нь мэдээллийн сувгийг өөрчлөх, урсгалыг нэмэгдүүлэх шаардлага байгааг харуулж байсан тул 2019 оны 4 дүгээр улирлаас иргэдийн гомдол, мэдээллийг 110 тусгай дугаарын утсаар хүлээн авах боллоо.

Гомдол, мэдээлэл хүлээн авах цээжлэх, тогтооход хялбар, ярианы төлбөргүй “110” тусгай дугаарын утсыг ажилд оруулснаар иргэд авлига, ашиг сонирхлын зөрчил,

авлигын гэмт хэрэг, хүнд сурталтай үйлчилгээ, албан тушаалтны ёс зүй, зүй бус шаардлагын талаарх мэдээллийг түргэн шуурхай хүргэх боломжтой болсон.

Энэхүү мэдээллийн суваг нь гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэхэд дэмжлэг болохын зэрэгцээ системийн тусламжтайгаар мэдээллийн сан үүсгэж, түүн дээр суурилан авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар, илүү үр дүнтэй, давхардал, хийдэлгүй зохион байгуулах нөхцөл бүрдэж байна.

Тусгай дугаарын утсаар ирүүлсэн гомдол,  
мэдээлэл /эхний 5 сарын байдлаар/







## АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

Зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр арга зүйн туслалцаа үзүүлэх, албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах, чадавхжуулах, цахимжуулах чиглэлээр хамтран ажилласны дүнд төрийн үйлчилгээний хүнд суртлыг арилгах, нээлттэй, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, шударга ёсны үнэлэмжийг сайжруулах чиглэлээр ахиц гарч байна. Тухайлбал,

Түрээсийн орон сууцанд хамрагдахаар бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг ил тод, иргэд хяналт тавих боломжтой болгох, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах Зөвлөмжийг Нийслэлийн Засаг даргад хүргүүлсний дүнд асуудал хариуцсан нийтийн албан тушаалтнууд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд холбогдоогүй байна.

Гадаад паспорт шинээр захиалах үйлчилгээг шуурхай хүргэх, төлбөр, хураамж төлөх үйлчилгээг дэвшилтэт технологийг ашиглан шинэчлэх зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд УБЕГ-аас үзүүлдэг 38 төрлийн үйлчилгээ, лавлагааны төлбөрийг гар утаснаасаа интернет банкаар төлөх боломжтой болсон.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа бүрэн дижитал бүртгэлд шилжүүлэхээр зөвлөмж өглөө.



Дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааг нээлттэй болгох ажлыг эрчимжүүлэх зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газар, орон нутгийн удирдлагуудад хүргүүлэв.

Боловсролын зээлийн сангаар суралцуулах журмыг шинэчлэхтэй холбогдуулан ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй, бусдад давуу байдал олгосон зохицуулалтыг тусгахгүй байх, зээлээр суралцагчийг зөвхөн төрд алба хашсан жилийг нь тооцож зээлийг нь чөлөөлөх зэрэг чиглэлээр зөвлөмж хүргүүлэв.

ЗТХЯ, АТҮТ-д зөвлөмж хүргүүлсний дүнд импортоор орж ирж буй авто тээврийн хэрэгслийн техник хяналтын үзлэгийн төлбөрийг давхардуулан тогтоосноор жилд дунджаар 30 орчим тэрбум төгрөг иргэд, аж ахуйн нэгж төлөх байсныг илрүүлэн таслан зогсоов.

### Сонгуулийн ерөнхий хороо, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд зөвлөмж хүргүүлэв


Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль болохтой холбогдуулан сонгуульд оролцох Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд зөвлөмж хүргүүлэв.

**Нам, эвсэл** нь хуулиар зөвшөөрөгдсөн хандив, хандивын хэмжээ, холбогдох хязгаарлалт, зохицуулалтыг чанд баримтлах, салбар нэгжүүд болон нэр дэвшигчдийг хууль бус хандив, санхүүжилтээс урьдчилан

сэргийлэх, хуульд заасан хугацаа, журмын дагуу тайлагнах, олон нийтэд ил тод болгох, мэдээлэх; (зөвлөмжийн хэсгээс)

**Сонгуульд нэр дэвшигч** нь төрийн албан хаагчийг сурталчилгаанд татан оролцуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хөрөнгийг ашиглах, эдийн болон эдийн бус зүйл амлах, санал болгох, өгөх зэргээр нийтийн албан тушаалтныг авлига, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд оруулахгүй байх. (зөвлөмжийн хэсгээс)

### Худалдан авах ажиллагаан дахь авлигын эрсдэлийг бууруулах талаар сайдуудад зөвлөмж хүргүүлэв



Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хамгийн олон, өндөр үнийн дүн бүхий төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн худалдан авах

ажиллагааг хэрэгжүүлж, санхүүжүүлэх сайд нарт зөвлөмж хүргүүлэв. Худалдан авах ажиллагаан дахь авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор ил тод, нээлттэй, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллахтай холбоотой анхаарах асуудлыг зөвлөмжид хамруулав.

## ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМ, ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД АВЛИГЫН ЭРСДЭЛ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Дэлхий нийтэд тархаад байгаа шинэ төрлийн “Ковид-19” вирусны халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд зориулж Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд бэлэн мөнгө, эд материал өгөх, үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх зэрэг хандивыг Улсын онцгой комисс, эрүүл мэнд, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагуудад сайн дурын үндсэн дээр өгч байна. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэх шаардлага тулгарч байгаа зэргийг харгалзан холбогдох байгууллагуудад Зөвлөмж хүргүүлэв. Үүнд:



**Улсын онцгой комисс**



**Засгийн газрын Хэрэг эрхлэх газар**



**Эрүүл мэндийн яам**



**Онцгой байдлын ерөнхий газар**



**Сангийн яам**



**Мэргэжлийн хяналтын ерөнхий газар**



**Нийслэлийн Засаг дарга**

Зөвлөмжид:

- ❖ Хандив, тусламжийн хөрөнгийг бүртгэх, зарцуулах гүйцэтгэлийг тайлагнахтай холбоотой арга хэмжээг зохион байгуулах;
- ❖ Орлого, зарцуулалтын талаар олон нийтэд нэг эх сурвалжаас мэдээлэл авах боломжийг олгох, үнэн зөв мэдээллээр хангах;
- ❖ Шийдвэр гаргах түвшний албан хаагчдад давуу байдал бий болгохоос сэргийлэх;
- ❖ Хандив, тусламжийн хөрөнгийг зөвхөн төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан авах зохицуулалтыг баримтлах;
- ❖ Хандивыг хүлээн авах, захиран зарцуулахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөх;
- ❖ Тендер сонгон шалгаруулалтад ил тод байдлыг хангах, тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй нөхцөлд шууд гэрээ байгуулсан этгээд буюу гүйцэтгэгч нь улс төрд нөлөө бүхий этгээд болон түүний хамаарал бүхий этгээд биш байхад онцгойлон анхаарах, авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй зөрчил илэрсэн тохиолдолд Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх зэрэг асуудлыг тусгав.

## ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАХ АЖЛЫН ШИНЭЧЛЭЛ

### Нуугдмал хөрөнгө, орлогын илрүүлэлт

АТГ-ын санаачилгаар татварын байгууллагатай хамтарч албан тушаалтны мэдүүлсэн орлого нь үнэн бодит эсэхийг тогтоох, нуугдмал орлогыг илрүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Тухайн онд хөрөнгө, орлого нь илт өссөн дүнтэй мэдүүлсэн 9 албан тушаалтан, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн үүсгэн байгуулсан, хувь эзэмшиж буй аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлого, бусад санхүүгийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтыг явуулснаар:



1,1

ТЭРБУМ ТӨГРӨГИЙН  
САНХҮҮГИЙН ЗӨРЧИЛ



71,4

САЯ ТӨГРӨГИЙН ТӨЛБӨР  
НОГДУУЛЖ УЛСЫН ТӨСӨВТ  
ТӨВЛӨРҮҮЛЭВ

### Яамдын 36 албан тушаалтны давхар ажил эрхлэлтийг таслан зогсоов

13 яамны 1165 албан тушаалтны хоёр буюу түүнээс дээших байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлүүлсэн эсэх байдалд хяналт шалгалтыг явууллаа. Уг шалгалтаар төрийн захиргааны 36 албан тушаалтан хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагад давхар ажил эрхэлж, цалин, урамшуулал авдгийг илрүүлэн таслан зогсоож, 11 албан тушаалтанд Сахилгын арга хэмжээг тооцуулсан байна.



## ИТХ-ын төлөөлөгч нь төрийн жинхэнэ албанд томилох нь авлигын эрсдэлийг үүсгэж байна

Улс төрийн албан тушаалтнууд нь төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох, мөн орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлж, давхар ажил эрхэлснээр ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргахад оролцох, нөлөөлөх, өөртөө болон бусдад давуу байдал бий болгох зэргээр авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бий болгож байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн нийт **8103** төлөөлөгчийн **124** нь сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд төрийн жинхэнэ албан тушаалд томилогдож тушаал шийдвэр гаргах, төсөв хөрөнгийг захиран зарцуулах, захиргааны бусад шийдвэрийг бие даан гаргах эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа үйлдлийг таслан зогсоох талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлд хандав.

## Улсын төсвөөс төлсөн төлбөрийг буруутай албан тушаалтнаас гаргуулахаар ажиллаж байна

Хууль бусаар нийтийн албанаас халагдсан, чөлөөлөгдсөн, шүүхийн шийдвэрийн дагуу ажилд эгүүлэн томилогдсон, нөхөн олговор олгосон байдалд дүн шинжилгээ хийв. Дүн шинжилгээ хийж үзэхэд 2017-2019 онд албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас ажилгүй байх хугацааны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөхөд нийт **4 тэрбум** төгрөгийн нөхөн олговор олгох шүүхийн шийдвэр гарчээ. Дээрх төлбөрт улсын төсвөөс нийт **1,3 тэрбум** төгрөгийг зарцуулсан нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зориулалтын бусаар зарцуулсан, улмаар төсөвт зохиомол хүндрэл учруулсан нөхцөл байдал тогтоогдож байна.

Хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах, улсын төсвөөс төлсөн төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх чиглэлээр буюу Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.3 "Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна" гэж заасны дагуу Үндэсний аудитын газарт асуудлыг тавьж шийдвэрлэхээр ажиллаж байна.

## Шударга ёс, хөгжил дэвшилд

### Хөрөнгө, орлогын эх үүсвэрийг шалгаснаар үндэслэлгүй хөрөнгөжсөн эсэхийг тогтоож байна

Албан тушаалтны өөрийн болон хамаарал бүхий этгээдүүдийн хөрөнгө, орлогын эх үүсвэрийг нягтлан шалгаж, хөрөнгийг газар дээр нь тулган шалгаж, баримтжуулан ажилладаг болов. Ингэснээр нуугдмал эд хөрөнгийг илрүүлж, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болох зөрчлийг илрүүлэхэд ахиц гарч байна. Үүний үр дүнд 34 албан тушаалтанд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болох үндэслэлээр хариуцлага тооцуулж, гэмт хэргийн шинж агуулсан зарим зөрчлийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.



Хууль, шүүхийн байгууллагын албан тушаалтан - **15**



ТӨХК-ийн удирдах албан тушаалтан - **5**



Яам, агентлагийн удирдах албан тушаалтан - **10**



Нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан - **4**

### Албан тушаалтны хөрөнгө, орлогын хянахад иргэдийн оролцоо чухал



Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг иргэд, олон нийт хянах боломжтой болов.

Төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийн мэдээлэл авах, хяналт оролцоог нэмэгдүүлэх зорилгоор <http://www.xacxom.iaac.mn> цахим сайтад албан тушаалтны ХОМ-ийг байршуулахдаа олон нийтэд ойлгомжтой байдлаар нээлттэй болгож байна. Тухайлбал,

*Орон сууц, барилга байгууламжийн төрлийг нийт 14 төрлийн үзүүлэлтээр задалсан, мөн хадгаламжийг "гадаад", "дотоод" гэж ангилж өгсөн нь иргэдэд ойлгомжтой болж хяналт тавих боломжийг нэмэгдүүлснээр албан тушаалтны ХОМ-ийг шалгуулах болон авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан иргэдийн гомдол, мэдээлэл 11,5 хүртэл хувиар өссөн үзүүлэлттэй байна.*

## Монголбанкны албан тушаалтнууд ББСБ үүсгэн байгуулах эрхгүй



“Монголбанканд ажилладаг нэр бүхий албан тушаалтнууд болон тэдний хамаарал бүхий этгээдүүд нь банк бус санхүүгийн байгууллага үүсгэн байгуулсан, хувь эзэмшиж байгаа” талаарх мэдээллийн мөрөөр холбогдох хяналтын үйл ажиллагааг явуулж Монголбанканд зөвлөмж хүргүүлэв. Ингэснээр

**“ Монголбанкны албан тушаалт-  
нуудын ажлын байрны  
тусгай шаардлагад банк бус  
санхүүгийн байгууллага үүсгэн  
байгуулсан, хувь эзэмшдэггүй  
байх гэсэн заалтыг тусгахаар  
болсон байна. ”**

Банкуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг Монголбанкны эрх бүхий удирдах албан тушаалтнууд нь барьцаалан эзэлдүүлэх, гадаад валют арилжааны чиглэлээр банк бус санхүүгийн байгууллага үүсгэн байгуулах, хувь эзэмших, эцсийн өмчлөгч ашиг хүртэгч байх ёсгүй юм.

## Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга замыг хэлэлцэв



Шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр хууль бус болох нь тогтоогдсон тохиолдолд шийдвэрийг хүчингүй болгох, гарсан сөрөг үр дагаврыг арилгах, учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан нөхөн төлүүлэх тогтолцоог бүрдүүлэхээр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөл болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлж буй өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар тодорхой асуудлуудыг дэвшүүлэн хэлэлцэж, тэдгээрийг шийдвэрлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр зөвлөмж гаргав.

**Төр, захиргааны албан хаагчдын ёс зүйн форумыг зохион байгуулав**



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт нийтийн албан тушаалтнуудыг ёс зүйтэй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр үе шаттай сургаж, чадавхжуулахаар тусгагдсаны дагуу Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Ил тод Улаанбаатар Академи” хамтран төр, захиргааны албан хаагчдын ёс зүйн форумыг зохион байгуулав. Ёс зүйн форумд ёс зүйн чиглэлээр мэргэшсэн судлаач, эрдэмтэн докторууд онол, практик хосолсон сонирхолтой илтгэлүүдийг тавьж, 110 гаруй оролцогч төрийн албаны үнэт зүйлс, ёс зүйн асуудал тулгарахад зөв гарц гаргалгааг олох чиглэлээр эргэцүүлэх асуулт, хариулт өрнүүлэн, хэлэлцэж, харилцан туршлага солилцов.

**“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт: олборлох салбарын ил тод байдал” уулзалт-хэлэлцүүлэг**



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Ашигт малтмалын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд 2017 онд орсон нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, хуулийн хэрэгжилтийг зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулав.

Хэлэлцүүлгийн дүнд эцсийн өмчлөгчийг бүртгэх маягыг шинэчилж бүртгэлийг эрчимжүүлэн, холбогдох байгууллагууд ажлаа уялдуулж, бүртгэлийн тоо мэдээний зөрүүг арилгахаар болсон. Мөн эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаарх эрх зүйн орчинг бүрдүүлэх, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч эздийг ил тод болгох асуудлаар зөвлөмж гарган, Авлигатай тэмцэх газраас Засгийн газарт хүргүүлсэн зөвлөмжид тусгав.



## **Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд иргэн хяналт тавих боломжийг бүрдүүлнэ**

ЗГХЭГ-тай хамтран төрийн байгууллагуудын өргөдөл, гомдол хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор “Төрийн байгууллагуудын өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах ажилтнуудын форум”-ыг зохион байгуулж, үйл ажиллагааг цахимжуулах, ажлын уялдаа холбоог хангах арга замыг хэлэлцэж зөвлөмж гаргав. Зөвлөмжийг хэрэгжүүлснээр иргэн гаргасан өргөдлийн шийдвэрлэлтийн явцыг хянах, өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийх, авлига, хүнд суртлыг халах ажлыг шинэ шатанд гаргах боломж бүрдэнэ.

## **Улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт сонгуулийн болон улс төрийн намын хуулийг шинэчлэх асуудлыг тусгасны дагуу холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд ажлаа чиглүүлж байна. Тухайлбал, “Транспэрэнси интернешнл Монгол”, “Шилэн нам” авлигын эсрэг түншлэлтэй хамтран “Улс төрийн намын тухай хууль: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвтэй хэлэлцүүлэг, “Улс төрийн

намын санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, авлигаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулав. Хэлэлцүүлгүүдийн дүнд Сонгуулийн хуулиудад зохих зохицуулалтыг тусгуулсны зэрэгцээ Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулахаар саналыг холбогдох саналыг хүргүүлэв.



## **Тусгай зөвшөөрлүүдийг мэргэжлийн холбоодод шилжүүлсэн ажлын үр дүнг хэлэлцэв**

Авлигатай тэмцэх газраас “Мэргэжлийн холбоодод шилжүүлсэн барилгын тусгай зөвшөөрлүүд: Асуудал, шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт оролцогчид асуудал, бэрхшээлийг тоо баримт, мэдээлэлд тулгуурлан ярилцаж, холбогдох сэдвүүдийг хэлэлцэв. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлснээр гарч буй хандлага, ололт дэвшил, хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх гарц, боломжийг төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллүүдийг оролцуулан хэлэлцсэнээрээ арга хэмжээ онцлог болов.

## Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулав

Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулж “Шударга байдал ба олон нийтийн итгэл” сэдвээр хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх газрын санаачилгаар зохион байгуулсан нэгдсэн зөвлөгөөнд

- ❖ Улсын дээд шүүх
- ❖ Шүүхийн ерөнхий зөвлөл
- ❖ Улсын Ерөнхий прокурорын газар
- ❖ Хууль зүй, дотоод хэргийн яам
- ❖ Цагдаагийн ерөнхий газар
- ❖ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
- ❖ Монголын Хуульчдын холбоо
- ❖ Монголын Өмгөөлөгчдийн холбоо зэрэг байгууллагын удирдах албан тушаалтнууд оролцов.



### АТГ-ын дарга, тэргүүн комиссар

**З.Дашдаваа:** Сүүлийн үед иргэд, олон нийтийн зүгээс төрийн байгууллагуудын шударга байдалд эргэлзэж, төрд итгэх итгэл алдарч байгаа талаар ярьж, бичих нь ихэслээ. Иргэд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагад хариуцлага тооцохыг шаардах боллоо. Нийгэмд авлигын шинжтэй мэдээлэл түгээмэл тархахын зэрэгцээ иргэд, олон нийт АТГ-аас, прокуророос, шүүхээс багагүй мэдээллийг шаардах боллоо. Бид шүүх, хуулийн байгууллагуудын нэр хүнд олон нийтийн дунд унасныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Энэ цаг үед нийгмийн шаардлагыг харгалзан тулгарч буй хүндрэл бэрхшээл, бодит нөхцөл байдлын талаар зөвлөлдөн, бодлого, стратеги, арга механизмаа ярилцах боломжийг олгохоор Авлигатай тэмцэх газраас санаачлан холбогдох байгууллагатай хамтран Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж байна.

“Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн”-ийг нээж хэлсэн үгнээс

Авлига, албан тушаалын гэмт хэргийг Авлигатай тэмцэх газар харьяаллын дагуу мөрдөн шалгадаг боловч хуулийн бусад байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо, амьд харилцаа зайлшгүй шаардлагатай.

Авлигын гэмт хэргийг үр дүнтэй шалгаж шийдвэрлэх нь дан ганц АТГ-ын үйл ажиллагаанаас биш, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаанаас ихээхэн хамааралтай тул хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тулгарч буй хууль зүйн болон практик хүндрэлүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцлээ.

Хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хиймэл оюун ухааныг ашиглах нөхцөл боломж бүрдээгүйгээс хойш хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагчид мэргэжлийн өндөр ёс зүйтэй байж, хуулийн хүрээнд, хараат бусаар, аливаад алагчлалгүйгээр хандан шийдвэр гаргаж ажиллах нь хуулийн байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, түүнийг хадгалах гол гарц юм.

Энэхүү зөвлөгөөн нь цаг үеэ олсон арга хэмжээ боллоо гэдгийг оролцогчид тодотгон тэмдэглэж, зөвлөгөөнөөс зөвлөмж гаргав.



## СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Авлигатай үр дүнтэй тэмцсэн улс орнууд авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэлээ болгон, иргэдийнхээ авлигын эсрэг боловсролд анхаарсан байдаг. Авлигатай тэмцэх газрын нэг чиг үүрэг бол олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын хор аюулыг ухуулан таниулах үйл ажиллагааг тасралтгүй явуулах явдал билээ.

Авлигыг жигших үзлийг төлөвшүүлэх, иргэдийн ухамсарт суулгах ажил бөгөөд дуу, шүлэг, зураг, ном, кино, жүжиг, лекц, яриа таниулга, сургалт, хэлэлцүүлэг зэрэг олон хэлбэрээр зохион байгуулж байна.

Авлигатай тэмцэх газрын стратегийн зорилгод “Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа олон нийтийн оролцоонд түшиглэдэг болно” хэмээн тусгасны дагуу иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоонд тулгуурлан оюутан, сурагч, залуучууд, иргэд, төрийн бус байгууллага, хувийн хэвшилд авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

### Сурагчдад “Найзын яриа” өдөрлөг зохион байгуулав



Хүүхэд, багачуудад шударга ёсны зан үйл төлөвшүүлэх, шударга ёсны үлгэр дуурайл бий болгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн сурагчдад зориулан “Найзын яриа” комикс номыг зохиож, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Сүхбаатарын талбайд “Найзын яриа” соён гэгээрүүлэх өдөрлөгийг зохион байгуулав.

## Залуучууд авлигын эсрэг "Цахим шийдэл"-ийг дэвшүүлэв

Авлигатай тэмцэх бодлого, зорилгыг хэрэгжүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, шинэ залуу үеийн хандлагыг эерэгээр өөрчлөх, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжих зорилгоор "Авлигын эсрэг 2019" чуулганыг Авлигатай тэмцэх газраас "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар", "Транспэрэнси интернэшнл Монгол" төрийн бус байгууллагатай хамтран зохион байгууллаа.



Шударга ирээдүй рүү тэмүүлсэн эрч хүчтэй, асуудлын шийдлийг олох хүсэлтэй залуучууд цуглан, зөв засаглал, шуурхай үйлчилгээ, дижитал гарц, олон нийтийн хяналт, тэр дундаа залуучуудын оролцооны талаар санал, туршлагаа солилцов.

Цаг хугацаа шаарддаг, олон шат дамжлагатай, дараалал үүсгэн чирэгдүүлдэг, хүнд сурталтай төрийн үйлчилгээг дэвшилтэт шинэ технологи ашиглан хийх дижитал шилжилт, өөрчлөх боломж болон цахим шийдлийг танилцууллаа.

Авлигаас ангижрах хамгийн үр дүнтэй шийдэл бол төрийн бүх үйлчилгээ цахимд шилжих явдал юм гэдгийг залуус онцолж байв.

Цахим шилжилт, технологийн хөгжлийг нэвтрүүлж, авлигагүй нийгмийг бүтээхэд залуусын идэвх, оролцоо чухал юм.



### АВЛИГЫН ЭСРЭГ яагаад ЗАЛУУЧУУД гэж?

"ЦАХИМ ШИЙДЭЛ" гэсэн сэдвийг голчлон анхаарч, цахим дэвшил, шийдлийг түлхүү ашигладаг нийгмийн идэвхтэй бүлэг болох залуучуудыг онилсон нь "зөв шийдвэр" байв. Залуучууд нэгдүгээрт, улс орны хөгжлийн гол хүч, хоёрдугаарт, шинэ техник, технологийн гол хэрэглэгч, гуравдугаарт, тэд хэзээ ч АВЛИГАД ӨРТӨХ БҮЛЭГ биш юм. Харин тэд хүчээ нэгтгэж, ойлголцож, зөв шийдлийг илэрхийлж чадвал нийгмээ АВЛИГААС ЦЭВЭРЛЭЖ ЧАДАХ хамгийн хүчтэй арми юм.

З.Батхуяг Улстөрч.мн



## Оюутнуудад “Үнэт зүйлсийн боловсрол” олгохыг чухалчлав



Дэлхий нийтийн глобал хөгжлөөс хоцрохгүйн тулд технологи, эдийн засаг, үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр хичээн зорихын зэрэгцээ иргэдийнхээ, ялангуяа ид сурч боловсрох, сэтгэх, бүтээх насандаа яваа сурагчид, оюутан залуусынхаа оюуны соёл, сэтгэлгээний хөгжил, ухамсар, хандлагыг зөв залж, чиглүүлж, дэмжиж тэтгэж байж нийгэм зүй зохистой, тэнцвэртэй хөгжинө. Ялангуяа хүний нийгмийн оршихуйн утга учир болох үнэт зүйл, ёс суртахууны талаарх мэдлэг, хүмүүжлийг залуу хүн бүрт ойлгуулж ухааруулах нь чухал. Тиймээс их, дээд сургуулийн оюутнуудад зориулан “Үнэт зүйлийн боловсрол” лекц, ярилцлага зохион байгуулав. Оролцсон 3000 гаруй залууст хувь хүний хийгээд улс орны хөгжлийн төлөөх үнэт зүйл, үнэт зүйлсийн чиг баримжааны талаар тодорхой ойлголт, санаа, сэдэл өгсөн арга хэмжээ боллоо.

*“Үнэт зүйл гэдэг бол мэдлэг, боловсрол юм. Мэдлэг боловсролтой байхын хэрээр илүү ёс зүйтэй, ёс суртахуунтай болдог. Илүү ойлгож мэдэж туршлагажихын хэрээр бусдыг болон өөрийгөө хүндэлдэг. Бидний аливаа шийдвэр гаргах зарчим, хандлага ч үүнийгээ дагаад өөрчлөгдөнө...”*

Илтгэлийн хэсгээс



## “Авлигатай тэмцэх газар- Танай хороонд” өдөрлөг




Авлигатай тэмцэх газраас иргэд, олон нийтэд авлигын хор аюулыг таниулах, шаардлагатай мэдлэг мэдээлэл олгох, зэргээр төрийн үйл ажиллагаанд хяналт тавих чадавхийг бий болгож, хамтран ажиллахыг чухалчилж байна. Энэ хүрээнд Сонгинохайрхан дүүргийн **6**, Баянзүрх дүүргийн **9** болон Хан-Уул дүүргийн **14** дүгээр хорооны иргэдэд “Танай хороонд” сэдэвт иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөгийг зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх үйл хэрэгт иргэдийг өргөнөөр татан оролцуулах, иргэдийн хууль эрх зүйн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, төрийн албан тушаалтны үйл ажиллагааг иргэд, олон нийт хянах ажлыг сайжруулах зорилгоор зохион байгуулж буй арга хэмжээг нийслэлийн бүх хороог хамруулна.

## 21 аймагт авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх цогц ажлыг зохион байгуулав

Авлигатай тэмцэх газраас орон нутгийн иргэдэд зориулан авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, уулзалт ярилцлага хийх, санал хүсэлтийг сонсох, гомдол мэдээлэл хүлээн авах зэрэг соён гэгээрүүлэх арга хэмжээг 21 аймагт зохион байгуулав.

“Авлигатай тэмцэх газар-Танай аймагт” иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг, “Олон нийтийн хяналт ба шударга ёс”, “Төрийн албан хаагч, эрх бүхий албан тушаалтанд зориулсан сургалт семинар” гэсэн 3 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэв.





## “Авлигатай тэмцэх газар-Танай аймагт” иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг



Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөгийн үеэр Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлахаас гадна авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлийн талаарх ерөнхий ойлголт, хор хөнөөл, үр дагавар, мөн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг, түүнд тавих иргэдийн хяналтын талаар мэдээлэл өгөв.

Уг өдөрлөгийн үеэр иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгч, төрийн үйлчилгээний талаар фокус ярилцлага хийж, иргэдийн өмнө тулгарч буй асуудал, бэрхшээлийг сонсож, санал гомдол хүлээн авав.

Иргэдэд авлигын эсрэг мэдлэг олгож, чадавхжуулан, хамтран ажиллахыг Авлигатай тэмцэх газраас чухалчилж байна.

## “Олон нийтийн хяналт ба шударга ёс” сэдэвт уулзалт



Уулзалтаар иргэдэд Авлигатай тэмцэх газрын зорилго, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газраас эрхлэн гүйцэтгэдэг судалгааны үр дүн, авлигын нөхцөл байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

Уулзалт, өдөрлөгийн үеэр **100** орчим иргэн Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, тэдний амьдралд тохиолдож буй асуудал, бэрхшээл, шийдвэрлэх арга зам болон хамтран ажиллах талаар санал бодлоо илэрхийлж, авлигын эсрэг тэмцэх үйл ажиллагаанд амжилт хүсэж байлаа.

“Олон нийтийн хяналт ба шударга ёс” сэдэвт уулзалтад **21** аймгийн **3496** иргэн оролцсон байна.

## Орон нутгийн төрийн албан хаагчдад зориулсан сургалт

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын албан хаагч, эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах зорилгоор зохион байгуулсан сургалт, семинарт **21** аймгийн **5238** албан хаагч оролцов.

### Иргэдэд авлигын эсрэг сургалт зохион байгуулав

2019 оны II хагасаас төрийн албан тушаалтнаас гадна иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшилд зориулсан авлигын эсрэг сургалт, зөвлөгөөн, чуулган зохион байгуулахад анхааран ажиллалаа.

Авлигын зардлыг татвар төлөгч, хэрэглэгч хэлбэрээр иргэд төлдөг тул авлигатай тэмцэх үйл хэрэгт иргэд, олон нийтийн хяналт, оролцоо, хандлага хамгийн чухал хүчин зүйл юм.

### Иргэдэд чиглэсэн сургалтад:



**3580** оюутан, сурагч



**3693** иргэн



**354** төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагч хамрагдав.

Төрийн болон төрийн бус **68** байгууллагын **6381** албан тушаалтанд тухайн байгууллагын хүсэлт, хэрэгцээ шаардлагыг харгалзан авлигын эсрэг сургалт зохион байгуулав.

## “АТГ- Олон нийтийн төв” фэйсбүүк пэйж хуудсыг нээн ажиллуулав



АТГ-ОЛОН НИЙТИЙН ТӨВ

Авлигаас урьдчилан сэрийлэх, соён гэгээрүүлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд энгийн ойлгомжтой, шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк хуудас нээн ажиллуулж эхлэв. “АТГ- Олон нийтийн төв” фэйсбүүк хуудас одоогоор **20.000** гаруй дагагчидтай байна. Монголын хамгийн их хандалттай фэйсбүүк хуудасны 2-рт эрэмблэгдэж байна.

2020.04.16-24-ний өдрийн байдлаар



## Сонсогчдын авлигын эсрэг мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч байна



Цахим орчинд мэдээлэл түгээх хүрээнд сүүлийн үед түгээмэл ашиглаж буй подкаст сувгийг үүсгэж, олон нийтэд авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх контентуудыг агуулга, төрөл хэлбэрээр нь ангилан оновчтой хүргэж эхэлсэн. Ингэснээр Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн контентуудыг аудио болон видео хэлбэрээр нэг дороос, шууд, шуурхай хүргэх, хүлээн авах, бусдад түгээх, сурталчлах боломж бүрдэж байна.




**MGLRADIO 88.3**, Гэр бүлийн радио **104.5** радиотой хамтран “Ашигтай халдвар”, “Ашигтай уриалга”, “Нэг дусал”, “Радио зөвлөгөө” зэрэг цуврал контент бэлтгэн сонсогчдод хүргэж байна.

## ▶ Шударга ёс, хөгжил дэвшилд

**Авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах сурталчилгаанд урлаг, спортын төлөөллийг татан оролцуулж байна**



Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, олон нийтийг хамарсан арга хэмжээг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж байна. Олны танил урлаг соёл, спортын алдартнуудтай хамтран авлигын хор хөнөөлийг таниулсан богино хэмжээний контент, шторкуудыг тасралтгүй хийж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэж байна.



Залууст авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, шударга ёсны үйл хэрэгт уриалах, тэдний дуу хоолойг хүргэх, хүч оролцоог бий болгох зорилгоор дуучин А Cool, Расгар нартай хамтран "Саарал хүмүүс" дуу, Турван бүдүүн" хамтлаг болон "Guys" хамтлагийн дуучин Уугий нартай хамтран "Зүүдэндээ" дууг бүтээж, клипжүүллээ.



## Авлигын эсрэг номын булан нээв

// Авлигатай тэмцэх газраас  
Үндэсний номын сан,  
Д.Нацагдоржийн нэрэмжит  
Улаанбаатар хотын нийтийн төв  
номын сан, МУИС-ийн номын  
сангуудад **“авлигын эсрэг  
номын булан”** нээлээ. //

**21** аймаг, **30** их, дээд сургуулиудын номын санд Авлигатай тэмцэх газраас гаргасан судалгаануудын эмхэтгэл, төрийн албан хаагчдад зориулсан гарын авлагууд, гадаад улс орнуудын авлигатай тэмцэж буй туршлага зэрэг 30 гаруй төрлийн номоор баяжилт хийлээ. Ингэснээр оюутан, судлаач, эрдэмтэд дээрх материалуудтай танилцаж, эрдэм шинжилгээ судалгааны эмхтгэлдээ ашиглах боломж бүрдүүлэв.



## “Шударга ёсыг бэхжүүлэх нь” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэв

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шударга ёсны ойлголт мэдлэг олгох, ёс суртахууныг төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг явуулахаар “Шударга ёсны хөтөлбөр”-ийг Азийн сан, Нийслэлийн Боловсролын газар, “Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг” ТББ-тай хамтран хэрэгжүүлэв. Уг хөтөлбөрт 84 сургуулийн 426 багш ахлах ангийн сурагчдыг хамруулан чадавхжуулав.

## Хоёр хотын цадиг-2019 үзэсгэлэн зохион байгуулав



Авлигыг бууруулахад мэдээллийн илтөд, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхийн ач холбогдлыг харуулсан **“Хоёр хотын цадиг- 2019”** үзэсгэлэнг “Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ-тай хамтран зохион байгуулав.

**Хүүхэд, өсвөр үе, залууст авлигын хор хөнөөлийг таниулах, шударга ёсыг эрхэмлэх үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн уралдаан, тэмцээнүүдийг зохион байгуулав**



Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шинэ технологи, шинэлэг санааг нэвтрүүлэх, тэдний авлигын эсрэг өрнүүлсэн санаачилгыг дэмжих, хамтран ажиллах замаар шударга, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх зорилгоор судлаач, багш, оюутан, сурагчдын дунд уралдаан зарлаж дүгнэв.

- ▶ “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэвшилтэт аргыг нэвтрүүлэх нь” /залуу эрдэмтэн, судлаачдад/
- ▶ “Шударга ёс: Хүн болох багаасаа” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан /ахлах ангийн сурагчдад/
- ▶ “Миний мэдэх шударга ёс” гар зургийн уралдаан /бага, дунд ангийн сурагчдад/

- ▶ “Түлхүүр” уралдаан/оюутан залууст/
- ▶ “New generation-No corruption” илтгэх ур чадварын нээлттэй тэмцээн /ахлах ангийн сурагчдад/ зохион байгуулсан юм.


Уралдаанд оролцогчид бие даан нийгмийн харилцаанд оролцох, нийгэм дэх авлига, хүнд суртал зэрэг сөрөг үзэгдэлд шүүмжлэлт байдлаар хандах, асуудлыг танин мэдэх, шийдвэрлэх арга зүй, чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлснээрээ ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.



## Төр, хувийн хэвшил, иргэдэд зориулан ном, гарын авлага гаргав

Авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчлах, нийгэмд учруулж буй хор аюулыг таниулах, хүүхэд, залууст шударга ёсны үнэ цэнэ, ойлголт, мэдлэг олгох зорилгоор төр, хувийн хэвшлийн албан хаагчид, иргэдэд зориулан ном, гарын авлагуудыг боловсруулан түгээв.

- Хувийн хэвшилд зориулан “Авлигаас урьдчилан сэргийлэх 9 зөвлөмж”
- “Хувийн хэвшлийн ёс зүй ба авлига”
- Оюутан, залууст зориулан зохион байгуулсан “Үнэт зүйлийн боловсрол” арга хэмжээний илтгэлүүдийн эмхтгэл
- “Олон нийтийн итгэл ба хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн”-ий илтгэлүүдийн эмхтгэл
- “Цахим шийдэл”-Авлигын эсрэг залуучуудын чуулганы илтгэлүүдийн эмхтгэл,
- “Төрийн албан хаагчийн ёс зүй”
- “Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь”
- “Мөнгө угаах гэмт хэрэг” гарын авлага
- “Монгол Улсын авлигатай тэмцэх тогтолцоо, эрх зүйн орчинд хийсэн 4 дэх удаагийн үнэлгээний зөвлөмж” тайлан
- “Найзын яриа” ном зэргийг боловсруулан гаргав.



## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

### Санхүүгийн мөрдөгчийн орон тоог шинээр бий болгов

Олон улсын мөнгө угаахтай тэмцэх алба(FATF)-наас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд тус газрын мөрдөн шалгах чиг үүрэг бүхий албан хаагчдын орон тоог нэмж, санхүүгийн мөрдөгчийн орон тоог шинээр бий болгон аймаг, орон нутагт ажиллах мөрдөгчийг нэмэгдүүлээд байна.

### Хөрөнгө буцаах сүлжээний 4 дүгээр бүгд хурлыг зохион байгуулав

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар нь Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний 6 дугаар бүгд хурлыг Даргалагч улсын эрх, үүргийг хэрэгжүүлж удирдан зохион байгууллаа.



АРИН-АП сүлжээний VI бүгд хуралд **22** улс, олон улсын **5** байгууллага, дотоодын төрийн **7** байгууллагын нийт **110** орчим төлөөлөгч оролцов.

Энэхүү хурлаар АРИН-АП сүлжээний гишүүн улс орнуудын төлөөлөгчид харилцан туршлага нээлттэй хуваалцаж, албан болон албан бус шугамаар мэдээлэл солилцох зөв зохистой арга замыг тогтоож, хууль бус хөрөнгийг буцаах чиглэлээр урт хугацаанд, үр дүнтэй, найрсаг хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр тогтов.



### АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа:

*Авлигын болон бусад гэмт хэргийн улмаас хууль бусаар гадагш гарсан хөрөнгийг царцаах, буцаан авах арга хэмжээ нь дан ганц нэг талын хүчин чармайлтаар үр дүнтэй болдоггүй, улс орон бүрийн ижил төстэй чиг үүрэг бүхий хууль хяналтын байгууллагуудын харилцан ойлголцсон, сайн хамтын ажиллагааны явцад бүрэн биеллээ олдог. Иймд бид бүхний хамтын ажиллагаа маш чухал.*

Бүгд хурлыг нээж хэлсэн үгнээс



## Олон улсад санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах сургалтууд

Авлигатай тэмцэх газар үндэстэн дамнасан авлигын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Швейцарийн Прокурорын газар, Австрийн Прокурорын газар, АНУ-ын Хууль зүйн департамент, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Хууль зүйн газар зэрэг байгууллагуудтай хамтран хууль бус хөрөнгийг буцаан авчрах, царцаах чиглэлээр мөрдөгчдийг чадавхжуулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ хүрээнд дараах олон улсын сургалтуудыг зохион байгуулж байна:



Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан түншлэл болох StAR буюу “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга”-тай хамтран хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянах, задлан шинжилгээ хийх чадавхи эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулав.



Австрали Улсын Холбооны цагдаагийн газартай хамтран Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний гишүүн 22 улс орны

төлөөлөгчдөд зориулсан “Нуугдмал хөрөнгө илрүүлэх: Гэмт хэрэг үйлдэх замаар олсон хөрөнгөөс ашиг хүртэх эцсийн өмчлөгчийг олж тогтооход нь” сэдэвт сургалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулав.



АНУ-ын Дипломат аюулгүй байдлын албаны олон улсад мөрдөн шалгах ажиллагаа явуулах газар, тус улсын Татварын албаны мөрдөн шалгах ажиллагаа явуулах газар, Техникийн туслалцаа үзүүлэх хэлтэс болон Ази, Номхон далайн бүс нутгийг хариуцсан АНУ-ын хууль сахиулах байгууллагуудын хамтарсан хүчнээс “Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.



НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон Дэлхийн банкны хамтарсан түншлэл буюу “Хулгайлагдсан хөрөнгийг буцаах санаачилга” /StAR/-аас “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа” сэдэвт ахисан түвшний сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулав.

## Шударга ёс, хөгжил дэвшилд

### Монгол Улсын авлигатай тэмцэх тогтолцоо, эрх зүйн орчинд хийсэн мониторингийн дүнг танилцуулав



Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Дэлхийн банк болон НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR) болон бусад гадаад улс орны ижил чиг үүрэг бүхий бусад байгууллагуудтай харилцан мэдээ, мэдээлэл туршлага солилцох, албан хаагчдыг сурган дадлагажуулах, чадавхжуулах зэрэг чиглэлээр харилцаа холбоогоо бэхжүүлэн хамтран ажиллалаа.

ЭЗХАХБ-ын Зүүн Европ, төв Азийн Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын авлигатай тэмцэх тогтолцоо, эрх зүйн орчинд хийсэн 4 дэх удаагийн үнэлгээний тайланг 2019 оны 3 дугаар сард тус сүлжээний Бүгд хурлын үеэр эцэслэн баталж, Монгол Улсын

Ерөнхий сайд, Авлигатай тэмцэх газрын дарга нарт ирүүлсэн.

ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг сүлжээний зөвлөхүүд Монгол Улсад ажиллан мониторингийн тайлан, зөвлөмжийг төрийн байгууллага болон олон нийтэд танилцуулав.

### Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг тайлагнав



Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн гишүүн орнууд тодорхой үе шаттайгаар конвенцийн хэрэгжилтийг тайлагнадаг. Монгол Улсын хувьд конвенцийн хэрэгжилтийг 2019 онд тайлагнахаар төлөвлөгдсөн тул Авлигатай тэмцэх газар тус Конвенцийн 2, 5 дугаар бүлгийн зүйл, заалт, дэд заалт тус бүрээр мэдээлэл бэлтгэж, тайлан гаргаж, 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлэв.

## Гэмт хэргийн шийдвэрлэлтийн урсгалд дүгнэлт хийх төсөл хэрэгжиж эхлэв



Азийн хөгжлийн банкны “ТА:9662-МОН: Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх техникийн туслалцаа” төсөл хэрэгжиж эхэллээ.

Төслийг хэрэгжүүлснээр авлигын гэмт хэрэг шийдвэрлэлтийн урсгалд (авлигын хэргийг мэдээлэх, мөрдөн шалгах, яллах, шүүхээр хянан шийдвэрлэх үе шат) дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний дагуу холбогдох хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийн зөвлөмж боловсруулах юм.

## Олон нийтийн зөвлөлийг дэмжин ажиллаж байна

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.7.5 дахь хэсэгт “авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх”-ээр заасны дагуу АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зэргээр үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна.



